# АЛШАА ДАНДАР ЛХААРАМБЫН СҮМБҮМЫН ГАРЧИГИЙН ТАЛААРХ НЭГЭН ДАМЖЛАГА ЭРЭМБЭ

*Д.Лувсанжамц \докторант*
*Шашин судлалын тэнхим*
*НШУС. МУИС*

***Түлхүүр үг**: Дандар лхарамба, Лувсанравжай, товег /хүртсэны тэмдэглэл /, санег /сонсоны тэмдэглэл/, жүдрим /дамжлага эрэмбэ /, эш, авшиг, хувь хүний эрдэм мэдлэгийг эзэмшиж, хэрэгжүүлсэн нийтлэг бус мэдээлэл, намтар, ном зүй, хоосон чанар.*

***Товч утга**: Алшаа Агваандандар/ 1758-1841/ лхарамбын намтар зохиол бүтээл түүний сэтгэлгээний онцлогийг судалгаа шинжилгээний хүрээнд оруулж байгаатай холбогдуулан түүний бүрэн зохиолийн гарчиг болон намтарын талаар шинэлэг баримт сэлтийг агуулсан энэхүү жүдрим / дамжлага эрэмбэ/ -ийг танилцуулснаар Агваан дандар лхарамбын талаарх мэдээ мэдээллийг илүү тодорхой болгох оролдлогыг хийж байгаа болно. Үүний зэрэгцээ монголчууд ном зүйн лавлагааг, намтар ном зүйг, каталогыг уламжлалт судалгаанд хэрхэн хэрэглэж байсыг авч үзсэн болно.*

Буддын судлалтан нар аливаа зохиол бүтээл, эш, авшиг зэргийг нарийвлан судалж, өөриймшүүлэн анхааран авахдаа уг номын гарвал үүсэл, зохиогч, уламжлан дамжуулж ирсэн хүмүүсийн нэрсийг бичиж тэмдэглэдэг уламжлалтай юм. Үүнийгээ ном хэлбэрт оруулан товег [1]/*хүртсэны тэмдэглэл* /, санег[2] /*сонсоны тэмдэглэл* /, жүдрим[3] /*дамжлага эрэмбэ* / хэмээн нэрлэдэг байна. Эдгээр нь зохиогчийн намтар, зохиолын агуулга, гарчиг, уламжлан дамжуулсан хүмүүсийн нэрс, ядам бурхадын тухай ойлголт, эшлэл тайлбар сэлтийг оруулсан зэрэг багтааж буй мэдээллийнхээ хувьд хураангуй, дэлгэрэнгүй хэдэн янз байгаа юм. Түвдэд хамгийн алдартай нь V Далай ламын айлдсан Жалбаан авын са-ег, монголд Халхын Заяа Бандидын айлдсан "*Шагжаан тойн Лувсанпэрэнлэйн гүн нарийн хийгээд агуу их дээдсийн номын олсон тодорхойн толь"*[4], Найдан са-ег бөгөөд Бурхан Буддын айлдсан сургаал Энэтхэг , Түвэд, Монголд хэрхэн дамжсаныг эндээс мэдэж болох ажээ. Монгол оронд дээхнэ үед Барин ламын хийдэд жүд дамжлага олныг хүртсэн дээдэс лам нар цуглан эш, авшигаа солилцож жүдийн томоохон төвлөрөл болж байсан тухай мөн Зава лам[5]/1867-1937/ тэнд хоёр сар саатаж байсан нь намтарт нь байдаг зэргийг гярган лам нар хүүрнэдэг.

Жүдрим нь зохиолын нэр, агуулга,бүтэц, гарчиг зэргийг хэрэглэгчдэд мэдээллэж байгаа талаасаа намтар ном зүйтэй төсөөтэй. Гэвч дамжлагыг тэмдэлэгч нь уг номыг зохиогч мэргэдээс эхлэн эш авшгийг шуудаар хүртсэн багшаа хүртэлх бүхий л дамжлагын багш нарыг нягт нямбай тэмдэглэн, хувь хүний эрдэм мэдлэгийг эзэмшиж, хэрэгжүүлсэн нийтлэг бус мэдээлэлийг агуулж байдгаараа онцлог юм. Лам нарын гар дээр түвэд хэл дээр бичидсэн жүдрим, са-ег, тов-ег нилээд байгаа боловч орчуулагдаж хэвлэгдсэн нь судлаач П.Ням-Очирын тайлбар хийж,шинэ үсэгт хөрвүүлсэн Халхын Зая Бандидын Тодорхойн толь[6] , Гэрэлт толиос[7] өөр энэ талын ном судалгаа манайд бараг үгүй байна.

**Зохиогчийн тухай :** Эл номын төгсгөлд бичиж тэмдэглэсэн хүний мэдээлэл байхгүй

[1] Thob yig
[2] Gsan yig
[3] Rgyud rims
[4] Sakya'I btsun pa blo bzang'phing las kyi zab pa dang rgya che'I dam pa'I chos kyi thob yig gsal ba'I melong las glegs las glegs bam bzhi pa bzhugs so
[5] Rtza ba bla ma Blo bzang rta dbyang,
[6] Халхын Заяа Бадидын Тодорхойн толь,Улаанбаатар, 2012
[7] Халхын Заяа Бадидын Гэрэлт толь,Улаанбаатар, 2012

байгаа юм. Баруун Чойрынхон Лондол явсрайн сүмбүмийн лүн[8] хүртдэг уламжлалтай байсан мөн энд өгүүлэгдэж буй Лхазун Лувсандамчой буюу Дамчой тойн нь Баруун Чойрын лам бөгөөд Данзан осор /1901-1978/ гавжийн багш нь байсныг үзэхэд уг номыг Данзан осор гуайн тэмдэглэл байж магадгүй байгаа юм. Үүнийг гавж Ш.Сонинбаяр ламтанаас асуухад гавж багшийн ном байж тун магадгүй, гэхдээ бичгийн хэв нь биш байна багшийн бичсэнээс хожим өөр хүн хуулж бичсэн байж болох юм гэж байгаа билээ. Эл номд "*Агвандандар лхарамба өөрийн зарим хэрэглэлийг газраас хөндий агаарт тогтоох, хийд яам хоёрын хооронд өлмийгөө газарт хүргэлгүй залрах,.... Ном зааж хөтлөх үеестээ өөрийн сууж буй лаврангийн багана, хана зэрэгт торж тулахгүйгээр гэнэт цааш нааш залран хувь төгөлдөр шавь бүгдэд харуулах тэргүүтэн санаанд багташгүй зохиол олон болой* "хэмээн хоосон чанарын онолыг илтэд эзэмшиж дадуулсы шинж байдал олныг үзүүлсныг өөрийн шавь нь нүдээр харсан тухай баримтыг агуулж байгаагаараа онцлог сонин юм.

**Номын бүтэц, онцлог**

Энд гарч буй зургаан хуудас гар бичмэл нь хэн зохиосон нь тодорхойгүй боловч Дандар лхарамбын намтар бүтээл , үйлс зохионгуйд холбогдолтой урьд өмнө нь олонд төдийлэн мэдээлэгдээгүй түвэд хэлээр бичигдсэн чухал бичгийн эх сурвалж юм.

Гавж Ш.Сонинбаяр ламтан "*Жүдрим тов-ег нь түүхийн чухал сурвалж болдог гэдэг шүү. Ялангуяа лам нарын намтарыг судалахад гол эх сурвалж болохоор үл барам багш шавийн барилдлага, хэдүй үеийн хүн байсан зэргийг эндээс тодорхой мэдэж болно"* хэмээн 2007 оны хавар нэгэн жижгэвтэр номыг надад ихэд чухалчлан өгсөн нь Дандар лхарамбын /1758-1841/ эл жүдрим байсан юм.

Номын бүтэн нэр:

Түвд: smra pa'i chu mchog lha rams pa ngag dbang bstan dar kyi gsung dbum kyi dkar chag rgyud rim bzhugs

Монгол: Өгүүлэхүйн манлай лхарамба Агваандандарын сүмбүмийн гарчиг, дамжлагын эрэмбэ оршивой.

Цаасны хэмжээ : 8см , 25 см

Хуудасны тоо: 6

Энэхүү зохиолын мөргөлийн шүлэг буюу эхлэл хэсэгт Бурхан багшид , дараагаар их Шарвака Одсүрэн, Гунгаавуу тэргүүтэй бурханы шашныг дэлгэрүүлэх үйлс тушаагдсан долоон дээдэс[9], Богд Зонхава, Гандан ширээт Лондол лам Агваанлувсан[10] /1758-1804/ ,

Алшаа Агваандандар/ 1758-1841/ лхарамба зэрэг дамжлагын лам нарт залбиралыг үйлджээ. Дараагаар Дандар лхарамбын намтар, түүний шавь Лувсанравжай[11]н намтарыг товч оруулж сүмбүмийн гарчиг , тэмдэглэгээнүүдийг хийгээд дамжлагын лам нарын нэрсийг дурьджээ.

Эл номд:

(...) -ээр түвдийн гийгүүлэгч 30 үсгийн дараалалаар номуудын нэрсийг ,

[...] -ээр хуудасны тоог,

{O} -ээр эш хүртээгүй номуудыг,

[8]Лхасын Барайвун хийдийн их лам, Гандан ширээт Лондол лам Агваанлувсан, Алшаа Дандар лхаарамба нарын бүрэн зохиолын эмхэтгэлийн эш

[9] Их шаравака Одсүрэн, Гунгаавуу, Шанайгойжан, Нивай,Хихига, Нагвуу, Лигтан

[10]Лхасын Барайвун хийдийн их лам, Гандан ширээт Лондол лам Агваанлувсан, Алшаа Дандар лхаарамбын багш

[11] Урад баруун хошуунд төрсөн.Аглагт гучин гурван жил суусан. Даяанч лувсанравжаа хэмээн алдаршсан Гүмбум хийдий монлам равжанба

{ЛХА} -аар зохиогчоос Лхарамба Жамбаа түүнээс монрамба Лувсанравжаа, Гүшири Агваанданпэл, Ба-рин равжамба Галсанчойнпэл, Найдан лам Цэпилдорж, Лувсанминжүүрдорж, гавж Гончогшэйрав, Ловон Лувсанжигмэддорж түүнээс Лхазүн Лувсандамчой гэсэн дамжлагыг,

{ДГА} –аар тэмдэгтэй нь зохиогчоос ямагтаас Гүшири Агваанданпэл, Ба-рин равжамба Галсанчойнпэл, Найдан лам Цэпилдорж, Лувсанминжүүрдорж, гавж Гончогшэйрав, Ловон Лувсанжигмэддорж түүнээс Лхазүн Лувсандамчой гэсэн дамжлагыг тэмдэглэв.

Дээрх тэмдэглэгээр хөөн үзэхэд зохиогч бээр хоёр ч ламын дамжлагаар уг номын эшийг бүрэн болгосон ба *"Даег -Чухал хураангуй [20], Даег-Саруул ухаантны хоолойн чимэг [59], Зохист аялгууны толийн хоёрдугаар бүлгийн адилтгал тодруулан үйлдэх [9], эш байдаг хэмээн соссон боловч олоогүй тул хайх хэрэгтэй"* гэснээс үзэхүл зохиогч эхэнд эшийг аваагүйг боловч зарим нэгийг хожим нөхөн авсан зэргийг эндээс ойлгож болно .

Алшаа Агваандандар/ 1758-1841/ лхарамбын намтар зохиол бүтээл түүний сэтгэлгээний онцлогийг судалгаа шинжилгээний хүрээнд оруулж байгаа үед энэхүү түүний зохиол бүтээлийн гарчиг болон намтарын талаар шинэлэг баримт сэлтийг агуулсан энэхүү жүдрим / дамжлага эрэмбэ/ олдсон нь Агваан дандар лхарамбын талаарх мэдээ мэдээллийг илүү тодорхой болгоход чухал хэрэглэгдхүүн болж байна. Үүний зэрэгцээ монголчууд ном зүйн лавалгааг, намтар ном зүйг, каталогыг уламжлалт судалгаанд хэрхэн хэрэглэж байсыг сонирхон судлаач нарт чухал хэрэглэгдхүүн болох юм.

**Өгүүлэхүйн манлай лхарамба Агваандандарын сүмбүмийн гарчиг, дамжлагын эрэмбэ оршивой \ Монгол орчуулга**

Сувасти.

Дээд гурван оргилын үзэсгэлэнт сүмбэр оройг чимэглэгч Шагжаан арслан охь

Даган баригч тушаагдсан долоо, Замбутивийн үзэсгэлэнт чимэг, Зонхов Богд

Шар малгайтны алтан титмийг баригч, дараачлан заларсан мэргэн бүтээлч Лондол эцэг шавь тэргүүтэн

Шаталсан алтан уулсын эрхи-дамжлагын лам нарт оройгоороо мөргөн зүрхнээсээ биширмүй

хэмээн сүжгийн орны дээдэд болсон Лхадан молом равжамба Агваандандар тэр бээр ерөөлийн хүчээр Алагшаагийн газарт 13-р жарны шороон эм туулай жил лагшин мэндэлжээ. Бага насандаа хуврага болж Алагшаагийн зүүн хийдэд шавилан сууж хожим Үйзэнд ном үзэхээр заларсан. Тэнд дээд мэргэн бүтээлч Лондол ренбүүчи тэргүүтний ойрын шавь болж Гоман дацанд шавилан таван ботийн номд суралцжээ. Лхарамбын нэр алдрын чинадад хүрээд өөрийн эх нутагтаа залран ирсэн. Ухааны таван оронд мэргэжсэн хэмээн яруу алдар нь түгсэн бөгөөд өөрийн зарим хэрэглэлийг газраас хөндий агаарт тогтоох, хийд яам хоёрын хооронд өлмийгөө газарт хүргэлгүй залрахыг бүгдээр харсан.

Эгэл хар хүний ханцуйтай хувцас өмсөх, тамхи болгоох тэргүүтэн гайхамшигтай үйл элдвийг зохиодог байв. Жаран есөн сүүдэр зооглохын үест Урад дунд гүний хошууны Баяншандийн ловон лам нар Цанид дацан байгуулахыг ламын сонорт айлтгасан тул тэнд залран Цанид дацан байгуулахын засал гүрэмд гурван жилийн өмнөөс бэлтгэн Дарь-Эхийн бумцог хорин нэг, Жамбалцанжид нэгэн бум, зургаан мутарт Махагалийн үндсэн тарни нэгэн сая, Ганжуурын уншлагыг олон удаа бүтээсэн. Чингээд далан хоёр сүүдэртэйдээ төмөр бар жил цанид дацанг байгуулан гурван жилийн хугацаанд игчааны эш уншлага, тайлбар хөтөлбөр зэргийг нарийвчлан дэлгэрэнгүй айлдсан байна. Мөн Их бодь мөрийн зэрэг, Дэлба шийврагийн эш номлол, өөрийн зарлиг зохиолын аль байгаа бүгдийн иш

номлол тэргүүтэн олныг хайрласан. Авшиг, даган зөвшөөлийн аймгаас анханд Ямандагарван гурван бурханы авшиг, Маналын авшиг, Дарь-Эхийн даган зөвшөөл тэргүүтэн олныг айлдсан.

Ном зааж хөтлөх үестээ өөрийн сууж буй лаврангийн багана, хана зэрэгт торж тулахгүйгээр гэнэт цааш нааш залран хувь төгөлдөр шавь бүгдэд харуулах тэргүүтэн санаанд багташгүй зохиол олон болой. Ийн Цанид дацанг байгуулах үйлийг дүүргээд наян гурван сүүдэр орчимд лагшийн биеийн цэцэгсийг цацал болгон Жан Шамбалын орноо Лондол ренбүүчийн дэргэд заларсан болой.

Лам тэрбээр өөрийн сүмбүмийн дамжлагыг хайрласан дэргэдийн шавь Лувсанравжай нь Урад баруун хошууны нутагт шороон эм могой жил мэндэлсэн бөгөөд Шандын хийдэд хуврага болжээ. Тэрбээр Гүмбүм хийдийн номын хүрээнд багтан таван ботийн номд суралцаж байх үест буюу хорин хоёр настайдаа Шандын хийдэд Цанид дацанг байгуулахад оролцон Дандар Лхарамбаас түүний сүмбүмийнх нь ихэнх ишийг хүртжээ. Жич Гүмбүмд буцаад ном эрдмээ дүүргэн Молом равжамбын дажийн сум эргүүлсний дараа Шандын хийдэд дахин морилон Цанидын багш тэргүүтний үйлийг эрхэлэсэн. Тэндээс аглагт агуйн мухарт гучин гурван жил илүүтэй бясалгалд оршсоноор даяанч Лувсанравжаа хэмээн алдаршсан. Тэрээр айлдахдаа "*Би нас хорин хоёр настайдаа түүний зарлиг зохиолын ишийг авсан боловч одоо нас наян хоёрыг хүртэл дамжлагыг сонсооч чамаас өөр үгүй*" хэмээн зарлигласан. Тэрбээр Шандын хийдийн унаган шавь Гүмбүм Молом равжамба Шэйравчойнзинд номын баяр хуримд зоригдон дамжлага ишийг хайрласан дагуу гарчиг дамжлагын эрэмбэ нь энд (га), (ха) зэрэг тэмдэг тавьсан гучин зургаан номноос найм, арван хоёр, хорин нэг, хорин долоо, хорин ес, гуч, гучин гурав, гучин зургаа зэрэг нь эхнээсээ лүн байгаагүй. Хорин дөрөв, хорин тав, хорин найм зэрэг гурван хэсгийн иш дамжлага байдаг хэмээн сонссон ч эс олсон тул хайх хэрэгтэй. Мэдэж танилцахад дөхмийг бодож иш дамжлага байгаа үгүйг эс ялган бүрэн гарчгийг бичвээс

(га) – д Аврал одуулахын ёсоос үүдсэн цадиг ]16],

(ха) -д Бурхан багшийг шалгарсан төрөлхтөнд нотолсон цадиг [16],

(га) - д Нотлохуйн ухааны бэрх оронд туслах тэмдэглэл [28],

(а) -д Үгүйсгэлийн нотолгооны хураангуй утга [9],

(жа) -д Зүгийн номын хүрд [11],

(ча) -д Өөрийн бэлгэ, ерийн бэлгийн агуулга [26],

(жа )-д Зоригдолыг шинжилсэн тайлбар [21],

(ня) -д {О} Үндэс бусдаас бүтсэны тайлбар (21),

(да) -д Билгийн зүрхний тайлбар[16],

(та) -д Мөрийн гурван эрхэмийн тайлбар [24] ,

(да) -д Шүтэн барилдлагын магтаалын тайлбар [26],

(на) -д {О} Ганцаас хагацсаны агуулга [43],

(ба )-д {ЛХА} Судрын зарим үгийн тайлбар [8],

(па) -д Тийн дарагчийн тогтоол тайлбар [25],

(ва) -д Цайны тахилын тайлбар [10],

(ма) -д Шавьд илгээсэн захидалийн тайлбар [49],

(за) -д Санваар өгөх зан үйлийн нөхвөр [22],

(ца) - д Эс өгснийг авсны доройтлын үнийн хэмжээг номлосон [13],

(за) - д Богдын магтаал сүсгийн цэнгэлийн тайлбар [30],
(ва) -д {ЛХА} Долоон утгат оюун судлахуй чухал хэрэгтэй [26],
(ша) -д {О} Номлох, хэлцэх, туурвих гурвын агуулга [20],
(са) -д Гучит тэмдэгийн утгыг ойлгоход хялбараар хураасан [30],
(а) -д Үсгийн номлол мэргэдийн амны чимэг [26],
(я) -д {О} Даег -Чухал хураангуй [20],
(ра) -д {О} Даег-Саруул ухаантны хоолойн чимэг [59],
(ла) -д Зохист аялгууны толийн гуравдугаар бүлгийн үлгэрлэн өгүүлсэн [34],
(ша) -д {О} Үлгэр чимгийн үүднээс ламыг магтсан [9],
(са) –д {О} Зохист аялгууны толийн хоёрдугаар бүлгийн адилтгал тодруулан үйлдэх [9],
(ха) -д {О} Захиа бичгийн аймаг [42],
(А) -д {О} Үсгийн эцсийн шинжлэл [14],
(ги) -д Праманагийн ерийн утгын үргэлжлэл [24],
. (хи) -д {ЛХА} Дара эхийн магтаал [15],
(ги) -д {О} Захиа бичгийн агуулга [19],
(и) -д ”Халуун хиншүү”д сэжгийг тасалсан [10],
(жи) -д {ДГА} Суртгаал хүмүүний ном баясгалант хурим [9],
(чи) -д {О} Элдэв зарлигийн аймаг [19]

нийт 665 /зургаан зуун жаран тав/ байна. Энд тэмдэглэгдээгүй эшийн дамжлага нь: Лхарамба Агваандандар, үйдлийг орхигч буюу самадаянч Лувсанравжай, Гүмбүм монрамба Шэйравчойнзин, Лувсанлопэл буюу өөр нэгэн алдар нь Гомбу хэмээх, Ловон Лувсанжамбалжамц, тэнцэшгүй зарлигийн ачит Лхазүн Лувсандамчой түүнээс би хүртсэн болой. {О} -ээр тэмдэглэсэн нугууд нь эш байхгүй болой. {ЛХА} тэмдэгтэй нь зохиогчоос Лхарамба Жамбаа түүнээс монрамба Лувсанравжаа үүнээс хойшхи нь дээрхи адил болой. {ДГА} тэмдэгтэй нь зохиогчоос ямагтаас Гүшири Агваанданпэл, Ба-рин равжамба Галсанчойнпэл, Найдан лам Цэпилдорж, Лувсанминжүүрдорж, гавж Гончогшэйрав, Ловон Лувсанжигмэддорж түүнээс ачит Лхазүн Лувсандамчой хүртсэн бөгөөд тэрбээр надад баясангуйгээр хайрласан болой.


## *ABSTRACT*

*I intend in this paper to make more clarifications on studies about Alshaa Lharampa Agvaandandar /1758-1841/ through this transmission lineage, which contains the complete list of his writings and new facts about his biography, and hence, to introduce about his biography, writings, and specific characteristic of his thoughts to research work communities. By doing so, I put some efforts to reveal how Mongolians used biographies and bibliographies in their traditional way of research work.*

## НОМ ЗҮЙ


1. Р.Бямбаа. Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл. II боть, Улаанбаатар 2004 он
2. *Ye-shes-thabs-mkhas*-Bka’rtzom qnang ba’I khal kha’I bla ma rnams kyi ntsan tho. Ulaanbaatar 1958
3. Lokesh Chandra: Materials for a history of Tibetan literature., New Delhi. 1963 (Sata-pitaka Series ).
4. Gombojab.S “Mongolcud-un tЦbed kele-ber johiyasan johiyal-un juyil “ ., *STUDIA MONGOLIA*., Tom.II., Fact.1., Олон улсын монгол хэл бичгийн анхдугаар их хурал. УБ.1960.